

Сүрьеэгийн (TB) халдвар

Tuberculosis (TB) Infection

Mongolian

Сүрьеэгийн халдвар (TB) гэж юу вэ?

Сүрьеэ (TB) нь сүрьеэгийн нянгаар үүсгэгддэг халдварт өвчин юм. Сүрьеэ (TB) нь агаараар дамжин халдварладаг.

Таны бие сүрьеэгийн (TB) нянгаар халдварласан ч танд ямар нэгэн зовиур мэдэгдэхгүй байх боломжтой. Үүнийг сүрьеэгийн халдвар (TB), сүрьеэгийн далд халдвар (TB) эсвэл "унтаа" сүрьеэ (TB) гэж нэрлэдэг. Та унтаа байдалд буй сүрьеэгийн халдвартай бол түүнийг бусдад халдварлуулах боломжгүй.

Хэрэв та сүрьеэгийн халдвар (TB) авсан бол үзүүлж байгаа эмчдээ хэлвэл зохино. Таны эмч таны энэхүү мэдээллийн нууцыг хадгалах болно. Та энэ талаар өөр хэн нэгэнд хэлэх шаардлагагүй.

Сүрьеэгийн халдвар (TB) нь сүрьеэгийн өвчнөөс (TB) ялгаатай (health.nsw.gov.au/Infectious/tuberculosis/Pages/tuberculosis-factsheets-languages.aspx). Сүрьеэгийн нян сэрэх эсвэл уг нянгийн тоо олшрох, үед сүрьеэгийн өвчин (TB) үүсэх бөгөөд таны биед зовиур илэрнэ. Хэрэв ийм зүйл тохиолдож, сүрьеэгийн өвчин (TB) таны уушгийг өвчлүүлсэн бол та бусдыг уг нянгаар халдварлуулах боломжтой. Ханиалгах, халуурах, шөнийн цагаар хөлрөх, огцом жин хаях зэргээр сүрьеэгийн өвчний (TB) шинж тэмдгүүд илэрнэ.

Би сүрьеэгийн халдвартай (TB) гэдгээ яаж мэдэх вэ?

Таныг сүрьеэгийн халдвар авсан эсэхийг мэдэхийн тулд эмч, сувилагч таныг шинжилгээнд хамруулахыг хүсч болно. Хоёр төрлийн шинжилгээ хийх боломжтой байдаг:

- Сүрьеэгийн (TB) цусны шинжилгээ (үүнийг QuantiFERON Gold эсвэл IGRA гэж нэрлэдэг) эсвэл
- Туберкулины арьсны сорил (TST эсвэл Mantoux тест гэж нэрлэдэг). Энэ нь гарын шууны арьсанд хийдэг жижиг тарилга байдаг.

Би сүрьеэгээр (TB) өвчлөх болов уу?

Таны дархлааны систем сүрьеэгийн (TB) нянг дарангуйлахыг хичээх болно. Ингэснээр таныг сүрьеэ өвчнөөс (TB) хамгаалж магадгүй юм.

Сүрьеэгийн (TB) халдвар авсан 10 хүн тутмын 1 нь сүрьеэгийн (TB) өвчнөөр өвчилдөг. Энэ нь хэдэн сарын дотор тохиолдож болох ч сүрьеэгийн (TB) нянгаар анх халдвар авснаас хойш олон жилийн дараа ч тохиолдож болно.

Дараах тохиолдлуудад сүрьеэгийн (ТВ) халдвар нь сүрьеэгийн (ТВ) өвчинг үүсгэх эрсдэл ихэсдэг:

- Нас маш бага (5 болон түүнээс доош насныхан) эсвэл 65 болон түүнээс дээш настай бол.
- Чихрийн шижин гэх мэт таны дархлааг сулруулдаг өвчтэй байх.
- Таны ууж буй эм дархлааг тань сулруулах нөлөөтэй байх.
- Та стресс ихтэй, эсвэл аливаа зүйлд хэт санаа зовниж байвал энэ нь таны дархлааг сулруулж болзошгүй.

Хэрэв та энэ талаар санаа зовж байгаа бол сүрьеэ (ТВ) өвчнөөр өвчлөх эрсдлийнхээ талаар эмчтэйгээ ярилцах хэрэгтэй.

Таны эмч сүрьеэгийн (ТВ) өвчлөлийг зогсоохын тулд тусгай антибиотик уухыг санал болгох эсвэл сүрьеэ (ТВ) өвчний шинж тэмдгийг эрт илрүүлэхийн тулд цээжний рентген шинжилгээг (health.nsw.gov.au/tb-cxr-monitoring) тогтмол хийлгэхийг зөвлөж болно.

Нэмэлт мэдээлэл

Сүрьеэ (ТВ) өвчний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл health.nsw.gov.au/tb цахим хаягаар зочилно уу.

Өөрийн хэлээр үнэ төлбөргүй туслалцаа авахыг хүсвэл Орчуулгын Үйлчилгээ (TIS)-ний 13 14 50 дугаарт залгана уу.